



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот

### Жуулчин тээврийн гэрээг шинэчлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/469 дугаар захирамж, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Улсын дугаарын хязгаарлалтгүйгээр нийслэл хотын авто замын хөдөлгөөнд оролцох 8-аас дээш хүний суудалтай жуулчин тээврийн хэрэгсэл эзэмшигчтэй байгуулах шинэчилсэн гэрээг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. “Жуулчны авто тээврийн үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5231 2003” стандартын шаардлага хангасан, жуулчин тээврийн зөвшөөрөлтэй тээврийн хэрэгсэлд хотын автозамын хөдөлгөөнд дугаарын хязгаарлалтгүй зорчих зөвшөөрөл олгож, гэрээ байгуулахыг Жуулчны аюулгүй байдал, үйлчилгээний байгууллага хариуцсан мэргэжилтэн /М.Баасандорж/-д, зөвшөөрөл олголт, гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтсийн дарга /Д.Ганболд/-д даалгасугай.

3. Тээврийн хэрэгсэл эзэмшигч аж ахуйн нэгж, хувь хүнээс гэрээний дагуу зөвшөөрлийн хураамж 5000 төгрөгийг, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд шилжүүлсэн байдалд хяналт тавьж ажиллахыг нягтлан бодогч /Б.Батбаатар/-д зөвшөөрсүгэй.

4. Жуулчин тээврийн хэрэгсэлд зөвшөөрөл олгох тухай Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2017 оны А/09 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА



Д.БАТСҮХ



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 05 сарын 02  
өдрийн А33 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

5284025 СБТ 48936 1118263502

**ЖУУЛЧИН ТЭЭВРИЙН ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ БҮХИЙ АЖ  
АХУЙН НЭГЖ, ИРГЭНД УЛСЫН ДУГААРЫН ХЯЗГААРЛАЛТГҮЙГЭЭР ХОТЫН  
АВТО ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ГЭРЭЭ**

2018 оны .. сарын .. ны өдөр

№..

Улаанбаатар хот

**Нэг. Ерөхий зүйл**

1. Энэ гэрээ нь Монгол улсын Иргэний хууль, Авто тээврийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Авто тээврийн хэрэгслээр ачаа, зорчигч тээвэрлэх дүрэм, “Жуулчны авто тээврийн үйлчилгээний ерөнхий шаардлага” MNS 5231 2003” стандарт болон авто тээврийн салбарт нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандартуудыг мөрдлөг болгон ажиллана

**Хоёр. Гэрээний хугацаа**

1. Гэрээг 2018 оны ..-р сарын .. ны өдрөөс эхлэн 2018 оны ..-р сарын .. ны өдөр хүртэл байгуулав
2. Гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
3. Гэрээний биелэлтийг 11 дүгээр сард НАЖГ-т ирүүлнэ.

**Гурав. НАЖГ-ын эрх үүрэг**

1. Жуулчин тээврийн хэрэгсэлийн үйлчилгээний соёл, стандартыг хангуулах талаар мэргэжил арга зүйн сургалт, зөвлөмж өгөх, дутагдал, доголдлыг арилгуулах,
2. Жуулчин тээвэрлэгчийг ур чадвартай, гадаад хэлний зохих шатны мэдлэгтэй байхыг шаардах
3. Автотээврийн үндэсний төвтэй байгуулсан гэрээ, TOURIST-ЖУУЛЧИН наалт, таних тэмдгийг үндэслэн улсын дугаарын хязгааралтгүйгээр хотын төв замын хөдөлгөөнд оролцох зөвшөөрлийг олгоно.
4. Жуулчин тээвэрлэлтийн талаархи санал гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ
5. Тусгай зөвшөөрлийг бусдад дамжуулсан, өөр маркийн автомашинд ашиглуулсан тохиолдолд Замын цагдаагийн газарт хандаж, Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авхуулах болон жолоодох эрхийг хасуулах хүртэл арга хэмжээ авна.
6. Жуулчин тээврийн хэрэгсэл эзэмшигч аж ахуйн нэгж, иргэнээс урд авсан хугацаа дууссан зөвшөөрлийг хураан авсны дараа сунгалтын тусгай зөвшөөрлийг олгоно.

**Дөрөв. Тээвэрлэгчийн эрх үүрэг**



1. Автотээврийн үндэсний төвтэй байгуулсан гэрээ, TOURIST-ЖУУЛЧИН наалт, таних тэмдэг, мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй байна
2. Жуулчдад цаг хугацааг сайн баримтлан хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган соёлтой үйлчилгээг хүргэнэ.
3. Жуулчин тээврийн үйлчилгээ үзүүлж байх үедээ гадаадын иргэн, жуулчны эрүүл мэнд, аюулгүй байдлыг хариуцаж, зорчигчийн салон, суудлын тав тухтай, цэвэр орчныг бүрдүүлсэн байна.
4. Жуулчинд үйлчилж байгаа үедээ буюу аяллын амралтын үед согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно
5. Энэ тусгай зөвшөөрлийг бусдад дамжуулахгүй, өөр маркийн автомашинд ашиглахгүй бөгөөд зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай хуулиар арга хэмжээ авхуулах болон жолоодох эрхийг хасах хүртэл хариуцлага хүлээнэ.
6. Жуулчин тээврийн хэрэгсэл эзэмшигч аж ахуйн нэгж, иргэн нь дахин шинээр тусгай зөвшөөрлийг авахдаа урьд онд авсан зөвшөөрлөө хураалгасан нөхцөлд шинээр гэрээ байгуулж, зөвшөөрлийг авна
7. Зөвшөөрлийн маягтын хэвлэлтийн зардал 5000 төг-ийн хураамжийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд тушаасан байна.
8. Жуулчин тээвэрлэхээс бусад тохиолдолд дугаарын хязгаарлалтгүй зорчих зөвшөөрлийг ашиглан авто замын хөдөлгөөнд оролцохыг хориглоно.

#### Гэрээ байгуулсан

Нийслэлийн Аялал жуулчлалын .....  
газрын жуулчны аюулгүй байдал .....  
хариуцсан мэргэжилтэн .....  
.....М.Баасандорж